

**Монголын эмийн сангийн томоохон сүлжээ компанийн нэг 1С: Enterprise програмын тусламжтай зохих хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөж байна.**

"Ази-Фарма" ХХК нь арав гаруй жилийн турш Монгол улсын нийт хүн амын гуравны нэгийг баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийн бараа бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байна. Компани нь эрчимтэй хөгжиж, өөрийн эмийн сангийн сүлжээ, эм ханган нийлүүлэх бөөний төвүүдийг нээж үйл ажиллагааны цар хүрээгээ улам өргөжүүлэн тэлсээр байна. "Ази-Фарма" ХХК нь өөрийн орны болон гадаадын хэдэн арван эм, эмийн хэрэгслийн холдинг компанийн түнш бөгөөд хэрэглэгчдэд 4 мянга гаруй нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг тасалдалгүй түгээн нийлүүлдэг. Харьцангуй өргөн хүрээний хэрэгцээний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх нь компанийн чухал ач холбогдолтой өрсөлдөх давуу тал хэдий ч худалдан авалт болон борлуулалтын үйл ажиллагааг чадварлагаар удирдан зохион байгуулж төлөвлөхөд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг байсан. Үүнээс гадна, компани нь ЭМД-ын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийг эмийн жорын маягтын дагуу олгох зэрэг бөөний болон жижиглэнгийн борлуулалтын төрөл бүрийн хөнгөлөлт, урамшууллын системийг хэрэгжүүлдэг билээ.

Бизнесийн үйл ажиллагааг үр дүнтэй зөв удирдан зохион байгуулж, хөгжүүлэх үүднээс үндэсний онцлогтой стандартад нийцүүлэн боловсруулсан удирдлагын үйл ажиллагааны чухал процессуудыг автоматжуулах "1С: Худалдааны удирдлага 8" програмын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн ашиглаж байна. Мэдээллийн систем нь холдинг компанийн жижиглэнгийн худалдааны цэгүүд болон бөөний худалдааны төвүүдийн үйл ажиллагааг цаг тухайд нь нэгдмэл байдлаар хянаж, удирдах боломжийг олгоно. Тиймээс борлуулалт хариуцсан компанийн ажилчид эмийн бүтээгдэхүүний тухай, найрлага, хэрэглэх заалт болон эсрэг заалт зэрэгтэй түргэн шуурхай танилцах боломжтой болсон юм. Энэ нь эргээд сүлжээ эмийн сангуудын харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулснаар хэрэглэгчийн үнэнч байдлыг нэмэгдүүлнэ.

Мөн 2016 онд компани нь шаардлагатай санхүүгийн тайлан мэдээллийг автоматаар бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг бүхэлд нь хөтлөх 1С: НББ дэд системийг ашиглаж эхэлээд байна.

"Ази-Фарма" нь бусад жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын адил 2016 оноос эхлэн шинэчлэн батлагдсан «Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын тухай хууль» -н дагуу өөрийн худалдан авагчдад шинэ стандартад нийцсэн төлбөрийн баримтыг хэвлэж өгөхийн тулд Татварын албаны нэгдсэн систем рүү баримт илгээх НӨАТ-ын урамшууллын систем буюу ebarimt-тай холбогдсон. 1С-Форус компанийн мэргэжилтний тусламжтай 1С мэдээллийн систем дээр шаардлагатай нэмэлт тохиргоо

хийснээр өнөөдөр татварын албаны нэгдсэн системтэй цаг тухайд нь мэдээлэл солилцож байна. Ингэснээр, 1С програмын бүтээгдэхүүн нь QR-код болон сугалааны дугаартай төлбөрийн баримт авах сонирхолтой шинэ худалдан авагчдыг татахад онцгой үүрэг гүйцэтгэж байна.

"Ази-Фарма" ХХК-н Гүйцэтгэх захирал Г.Баяржаргал үйл ажиллагааны автоматжуулалт, түүний үр дүнгийн талаар: ""1С:Enterprise 8" бааз дээр үүсгэсэн систем нь миний ажлыг ихээхэн хөнгөвчилж, би өдөр тутам хийдэг нэг хэвийн ажлаас чөлөөлөгдсөнөөр бизнесийн шинэ санаа, шинэ төсөл дээр ажиллах цаг зав сайтай болсон. Төсөл хэрэгжүүлснээр өмнө нь таамаглаж төсөөлж ч байгаагүй шинэ боломжууд компанийн өмнө нээгдсэн" гэж хэлсэн юм. Мөн энэхүү систем нь хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэнээс гадна өөрчлөлт орох бүрд 1С-Форус компанийн мэргэжилтнүүд шуурхай шинэчилж өгдөг гэдгийг хэлэх нь чухал юм.

"Ази-Фарма" ХХК нь Монгол улсын эм, эмийн хэрэгслийн зах зээлд 10 гаруй жил амжилттай үйл ажиллагаа эрхлэн явуулж буй томоохон компани юм. "Ази-Фарма" ХХК нь өөрийн сүлжээ эмийн сан, эм ханган нийлүүлэх төвүүдээр дамжуулан Монголын хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд эм, эмнэлгийн хэрэгслийн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлдэг. Ойрын хугацаанд өөрийн үйл ажиллагааг улам өргөжүүлэхээр төлөвлөж байна. Өнөөдрийн байдлаар 200 гаруй ажилтны хамтын хүчээр Монгол улсын нийт хүн амын гуравны нэгийг 4000 гаруй нэр төрлийн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байна. Компани нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, чанар аюулгүй байдлыг хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлж Монголын нийт хүн амын хэрэгцээг хангахаар зорин ажиллаж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БАЯРЖАРГАЛ

**Холбоо барих мэдээлэл:**

**Хаяг:** Монгол улс Улаанбаатар хот 2-р хороо Энхтайваны  
ергөн чөлөө, Гранд плаза цогцолбор 1105 тоот

**Утас:** (976) 7007-5511, (976) 7007-6611

**Факс:** (976) 7007-6611

**E-mail:** [info@asiapharma.mn](mailto:info@asiapharma.mn)

---